



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/10

Хөхбүрд

Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/202 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 25-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Мал, эмнэлгийн ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу малын дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжийн эмч нарт даалгасугай.

3. Сумын хэмжээнд дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн хугацаанд тухайн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

4. Дархлаажуулалтын товыг мал эмнэлгийн тасаг тогтоосон хугацаанд, багийн Засаг дарга нар, малчин мал бүхий иргэдэд зарлан мэдээлэл хүргэх ажлыг хариуцуулсугай.

5. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажилд хяналт шалгалт хийхэд шаардлагатай шатахууныг Засаг даргын Тамгын газрын шатахууны зардлаас олгохыг нягтлан бодогч (Л.Алимаа)-д зөөвөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Ганцоож)-д даалгасугай.

ДАРГА Ж.ХАТАНБААТАР



642301047